



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/197

Булган сум

**Бага ангийн сурагчдын анги нийтийн
масс олимпиадыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, “Амжилтын гараа хөтөлбөрийг батлах тухай” XI/76 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Амжилтын гараа” хөтөлбөрийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын дунд зохион байгуулах анги нийтийн масс олимпиадыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг 1 дүгээр, олимпиадыг зохион байгуулах журмыг 2 дугаар, төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Олимпиадад шаардагдах 3,860,000 (гурван сая найман зуун жаран мянга) төгрөгийг “Амжилтын гараа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3. Олимпиадыг үр дүнтэй зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Боловсролын газрын дарга (Ц.Цолмонбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026. оны
03. дугаар сарын 17-ны/ний өдрийн
А/197 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



АЙМГИЙН ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: Ж.Энхцогт (Боловсролын газрын Бага боловсрол хариуцсан ахлах арга зүйч)

Гишүүд: (Ерөнхий боловсролын сургуулиудын Бага боловсрол хариуцсан сургалтын менежерүүд)

Нарийн бичгийн дарга: Т.Дорждэрэм (Монгол Улсын зөвлөх багш, Сэлэнгэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн Сургалтын менежер)

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 17-ний өдрийн
А/197 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

**БУЛГАН АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
БАГА АНГИЙН СУРАГЧДЫН АНГИ НИЙТИЙН МАСС ОЛИМПИАДЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг зүйл:

1.1.Энэхүү журмыг Булган аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын бага ангийн сурагчдын дунд зохион байгуулах анги нийтийн масс олимпиадын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, дүгнэхэд мөрдлөг болгон ашиглана.

1.2.Анги нийтийн масс олимпиад нь бага боловсролын сургалтын чанарыг сайжруулах, сурагчдын авьяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, хичээл сургалтын агуулгын хэрэгжилтийг хангах, сурлагын хоцрогдлыг бууруулахад чиглэнэ.

1.3.Олимпиадын даалгавар нь сурагчдын онолын мэдлэг, практик ур чадвар, сэтгэн бодох чадварыг сорьсон байх бөгөөд жил бүр агуулгын түвшинг ахиулж, улс болон бүсийн олимпиадын түвшинд ойртуулах зарчмыг баримтална.

Хоёр.Зорилго:

2.1.Бага боловсролын сургалтын чанарт ахиц гаргах, суралцагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх, хичээлийн агуулгын хэрэгжилтийг сайжруулж, сурлагын хоцрогдлыг бууруулах.

2.2.Тоо бодох, уншиж ойлгох чадварыг хөгжүүлэх арга зүйг дэмжих, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах.

2.3.Бага боловсролын багш нарын байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээний түвшинг ахиулах.

Гурав.Олимпиадын зохион байгуулалт:

3.1.Анги нийтийн масс олимпиадыг аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын 2-5 дугаар ангийн сурагчдын дунд Монгол хэл, Математик хичээлийн төрлөөр жил бүр уламжлал болгон зохион байгуулна.

3.2.Олимпиадыг жилд 2 удаа зохион байгуулна.

✓ I даваа-Сургуулийн түвшинд комисс байгуулан зохион байгуулна.

✓ II даваа-Бүсийн түвшинд зохион байгуулж, сургуулиуд хянагч багш нараа харилцан солилцоно.

3.3. Олимпиадын хугацаа

✓ I даваа: 12 дугаар сарын эхний долоо хоног (12 дугаар сарын 03–04)

✓ II даваа: 3 дугаар сарын гурав дахь долоо хоног (3 дугаар сарын 18–19)

3.4.Олимпиадын даалгаврыг сургалтын хөтөлбөрийн заавал судлах агуулгын хүрээнд боловсруулж, суралцахуйн зорилтод нийцүүлнэ.

3.5.Даалгаврыг Боловсролын газрын ахлах арга зүйч болон бага боловсролын багш нарын төлөөлөл бүхий ажлын хэсэг боловсруулж, хянан баталгаажуулна.

3.6.Олимпиадын зохион байгуулалтыг Боловсролын газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг хариуцна.

3.7.Олимпиадын байр эзлүүлэлтийг II давааны дүнгээр нэгтгэн тодорхойлно.

3.8.Оролцогч анги, сурагчдын тооноос үл хамааран нийт гүйцэтгэлээр дүгнэнэ.

3.9.Олимпиадын материал, даалгаврын нууцлал, шударга байдлыг тухайн судлагдахуун хариуцсан арга зүйч болон сургуулийн сургалтын менежер хариуцна.

3.10.Төрөл тус бүрийн дэлгэрэнгүй удирдамжийг тусгайлан боловсруулна.

3.11.Олимпиадын хугацааг шаардлагатай тохиолдолд Боловсролын газрын даргын шийдвэрээр өөрчилж болно.

Дөрөв.Олимпиадын дүн, байр эзлүүлэх журам:

4.1.Судлагдахуун бүрээр эхний 3 байр эзэлсэн ангиудыг шалгаруулна.

4.2.Шагнал урамшуулал

Байр Шагнал

I байр 400.000 төгрөг

II байр 300.000 төгрөг

III байр 200.000 төгрөг

Тусгай байр Батламж

4.3.Байр эзэлсэн ангийн багш, сурагчдыг зохих журмын дагуу урамшуулна.

4.4.Олимпиадад амжилттай оролцсон сургуулийн удирдлага, сургалтын менежерийг “Олимпиад зохион байгуулалтын сайн туршлага”-аар алдаршуулж урамшуулна.

Тав.Санхүүжилт:

5.1.Олимпиадын үндсэн санхүүжилтийг Булган аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн “Амжилтын гараа” дэд хөтөлбөрөөс санхүүжүүлнэ.

5.2.Олимпиадын хянагч багшийн бичиг хэрэг, унаа, хоолны зардлыг тухайн сургууль (байгууллага) хариуцна.

Зургаа.Олимпиадын үр дүн:

6.1.Бага боловсролын сургалтын чанар сайжирч, сурагчдын мэдлэг, чадвар, сурах идэвх нэмэгдсэн байна.

6.2.Суралцагчдын чанарын үнэлгээ аймаг, улсын дундаж үзүүлэлтээс дээш ахисан байна.

6.3.Хичээлийн агуулгын хоцрогдол буурч, сурлагын амжилт дээшилсэн байна.

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 17-ны/ний өдрийн
А/197 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт



2-5 ДУГААР АНГИУДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ
МАСС ОЛИМПИАДЫН ТӨСӨВ

д/д	Шагналын төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн дүн	Бүгд олгох
1	2	3	4	5
1	1 дүгээр байр	4	400,000	1,600,000
2	2 дугаар байр	4	300,000	1,200,000
3	3 дугаар байр	4	200,000	800,000
4	Өргөмжлөл	12	5,000	60,000
5	Цом	4	50,000	200,000
Нийт дүн				3,860,000

--o00o--